



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 31 (316)

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:**

- *Завхан аймгийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:**

- *Орон сууц барих ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай*
- *Нэрэмжит болгох тухай*
- *Үл хөдлөх хөрөнгө худалдах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2003 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2003 оны наймдугаар сарын 20

№ 31 (316)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

478. Завхан аймгийн зарим хүнийг  
одон, медалиар шагнах тухай Дугаар 140 773

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

479. Орон сууц барих ажлыг эрчимжүүлэх  
зарим арга хэмжээний тухай Дугаар 143 777

480. Дүрэм шинэчлэн батлах тухай Дугаар 144 777

481. Конвенци хэрэгжүүлэх зарим арга  
хэмжээний тухай Дугаар 145 780

482. Хэлэлцээр батлах тухай Дугаар 148 780

483. Хэлэлцээр батлах тухай Дугаар 149 781

484. Хэлэлцээр батлах тухай Дугаар 150 781

485. Нэрэмжит болгох тухай Дугаар 151 781

486. Хөтөлбөр батлах тухай Дугаар 160 782

487. Хөтөлбөрийн хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай Дугаар 162 788

488. Үл хөдлөх хөрөнгө худалдах тухай Дугаар 163 788

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 7 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 140

Улаанбаатар  
хот

Завхан аймгийн зарим хүнийг одон,  
медалиар шагнах тухай

Завхан аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, төр захиргаа болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг тус аймаг байгуулагдсаны 80 жилийн ойг тохиолдуулан одон, медалиар шагнасугай.

#### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Нацагийн Аавхүү	-Завхан аймгийн Яруу сумын малчин	3. Анандын Совд	уул" мал эмнэлгийн дарга -Завхан аймгийн барилга угсралт, худалдааны "Зуурмаг" ХХК-ийн кранчин
2. Гончигоогийн Алтайхүү	-Завхан аймгийн Сонгино сумын "Сонгинохайрхан		

#### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Чойжингийн Агваанзундуй	-Завхан аймгийн Баянтэс сумын цаг уурын өртөөний ахлах техникч	3. Жанлавын Бэнцэ	-Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын малчин
2. Чимэдийн Баатарпүрэв	-Завхан аймгийн Сонгино сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан	4. Рагчаагийн Батбазар	-Завхан аймгийн Тосонцэнгэл сумын өндөр настан, ахмад малын эмч

5. Тангадын Буянжаргал	-Завхан аймгийн Алдархаан сумын Засаг дарга	худалдааны "Дөрвөлжин таван эрдэнэ" хоршооны орлогч дарга
6. Ганжууржавын Ванчиндорж	-Завхан аймгийн Түдэвтэй сумын засаг даргын Тамгын газрын байгаль орчны улсын байцаагч	22. Даваагийн Миаадорж -Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын эпидемиологч эмч
7. Онигын Галдан	-Завхан аймгийн Цэцэн-Уул сумын малчин	23. Галингийн Мондоон -Улсын нөөцийн газрын Завхан аймаг дахь салбарын эрхлэгч
8. Доосуугийн Гүсэнжав	-Завхан аймгийн Нөмрөг сумын дунд сургуулийн зөвлөх багш	24. Лхамсүрэнгийн Норжинжав -Завхан аймгийн Улиастай сумын "Намчинманба" ерхийн эмнэлгийн их эмч
9. Баатархүүгийн Гэрэлтогтох	-Завхан аймгийн Хөгжимт жүжгийн театрын гоцлол дуучин	25. Балдоржийн Нямсүрэн -ХААН банкны Завхан аймаг дахь салбарын захирал
10. Мэнгээгийн Даваа	-Завхан аймгийн Сантмаргаз сумын малчин	26. Сүрэнхүүгийн Нямсүрэн -Завхан аймгийн Аудитын газрын шинэжээч
11. Санжсүрэнгийн Даваа	-Завхан аймгийн Тосонцэнгэл сумын өндөр настан, ахмад тээвэрчин	27. Даржаагийн Өлзийхутаг -Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын зааварлагч
12. Дүгэрийн Давааням	-Завхан аймгийн Шүлүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын дарга	28. Дашпунцагийн Пүрэвжав -Завхан аймгийн Нэгдсэн эмнэлгийн их эмч
13. Рэнжингийн Дорлиг	-Завхан аймгийн Яруу сумын малчин	29. Бэгзээхүүгийн Пүрэвдорж -Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн эрхлэгч
14. Хасбатын Жамц	-Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын малчин	30. Дүгэрсүрэнгийн Пүрэвдорж -Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга
15. Пүрэвийн Жамъянлодой	-Завхан аймгийн Тосонцэнгэл сумын өндөр настан, төр захиргааны ахмад ажилтан	31. Норовсамбуугийн Пүрэвсүрэн -Завхан аймгийн Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл
16. Жигжжэвийн Зиймаагий	-Завхан аймгийн Нөмрөг сумын дунд сургуулийн захирал	32. Дашпилийн Самбуудорж -Завхан аймгийн Улиастай сумын "Жавхлант" цогцолбор сургуулийн физикийн багш
17. Цанжидын Ишдорж	-Завхан аймгийн Эрүүл мэндийн газрын зурх судасны өвчинтэй тэмцэх, сэргийлэх хөтөлбөрийн зохицуулагч	33. Дашзэвэгийн Сандагдорж -Завхан аймгийн Улиастай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
18. Шагдарсүрэнгийн Ишдорж	-Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын авто замын улсын байцаагч	34. Шагдарсүрэнгийн Сандаг-Очир -Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын хөдөлмөр, нийгмийн халамжийн байцаагч
19. Цэдэнбалжирын Лэгдэнжав	-Завхан аймгийн "Отгонтэнгэр" рашаан сувиллын ардын эмчилгээний ажилтан	35. Дэлгэрцогтын Самбадагдан -Завхан аймгийн Улиастай сумын 4 дүгээр дунд сургуулийн хөдөлмөрийн багш
20. Агданбуугийн Магсаржав	-Завхан аймгийн Улиастай сумын өндөр настан, ахмад багш	36. Алгаагийн Самданбазар -Завхан аймгийн Сонгино сумын Иргэдийн
21. Цэвэлжавын Мижиддорж	-Завхан аймгийн Дөрвөлжин сумын үйлдвэрлэл,	

37. Жигмэдийн Үнэнбат	төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга -Завхан аймгийн Улиастай сумын өндөр настан, ахмад тээвэрчин	42. Дамирангийн Цолмон	үйлдвэрлэлийн "Бэрсүм" ХХК-ийн инженер -Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын малчин
38. Дамдингийн Халтар	-Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл	43. Бэгзийн Чимэддорж	-Завхан аймгийн Улиастай сумын "Завхан-Эрчим хүч" ХХК-ийн инженер
39. Цэдэнсодномын Халтар	-Завхан аймгийн Улиастай сумын 1 дүгээр дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш	44. Өсөхийн Чулуунбаатар	-Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
40. Зундуйн Хүрэлбаатар	-Завхан аймгийн Улиастай сумын үйлдвэрлэл, үйлчилгээний "Тэсийн гол" ХХК-ийн ерөнхий захирал	45. Бат-Очирын Ядам	-Завхан аймгийн Завханмандал сумын өндөр настан, ахмад малчин
41. Жамсрангийн Цагаан	-Завхан аймгийн Улиастай сумын барилгын	46. Чадраабалын Янсан	-Завхан аймгийн Улиастай сумын 5 дугаар цэцэрлэгийн багш

### ЦЭРГИЙН ГАВЬЯНЫ ОДОНГООР:

1. Бааварын Доржготов	-Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагч, цагдаагийн хошууч	3. Догсомын Ширэндэв	настан, ахмад дайчин -Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Цэргийн штабын нөхөн хангалт, тоо бүртгэл хариуцсан офицер, дэд хурандаа
2. Дондогийн Дэнзэн-Очир	-Завхан аймгийн Цаганчулуут сумын өндөр		

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Ванчиндоржийн Аюушжав	-Завхан аймгийн Прокурорын газрын бичээч	9. Будбазарын Ванчиндорж	-Завхан аймгийн Улиастай сумын Жаргалант багийн Засаг дарга
2. Содномдаржаагийн Баасанхүү	-Завхан аймгийн Улиастай сумын "Ирээдүй" цогцолбор дунд сургуулийн захирал	10. Сэндэнхүүгийн Ваня	-Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга
3. Аюушжавын Балжинням	-Завхан аймгийн Тэс сумын соёлын төвийн эрхлэгч	11. Ившинхоролын Галт	-Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
4. Балдангийн Батдорж	-Завхан аймгийн Улиастай сумын "Жавхлант" цогцолбор дунд сургуулийн захирал	12. Батжаргалын Готов	-Завхан аймгийн Эрүүл мэндийн газрын хоол судлаач, их эмч
5. Өлзийбадрахын Баттөмөр	-Завхан аймгийн Улиастай сумын Товцог багийн Засаг дарга	13. Гуррагчаагийн Гүнчинсүрэн	-Завхан аймгийн Тосонцэнгэл сумын "Хан хөвч" ХХК-ийн ажилчин
6. Даваагийн Бэгзсүрэн	-Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг даргын орлогч	14. Намжилын Дашзэвэг	-Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар дунд сургуулийн бага ангийн багш
7. Чойсүрэнжавын Бямбадорж	-Завхан аймгийн Төлмөн сумын Засаг даргын орлогч	15. Цэрэндоржийн Должинсүрэн	-Завхан аймгийн Шүлүүстэй сумын Засаг даргын Тамгын газрын архивын эрхлэгч
8. Гэндэнжавын Бямбасүрэн	-Завхан аймгийн Улиастай сумын 1 дүгээр дунд сургуулийн хөдөлмөрийн багш		

16. Равдангийн Дэлгэр	-Завхан аймгийн Яруу сумын Засаг дарга	33. Бат-Очирын Сүрэн	үйлчилгээний «Завхан баялаг» ХК-ийн ажилчин
17. Артхүүгийн Дэмбэрэлнямбуу	-Завхан аймгий Улиастай сумын 1 дүгээр дунд сургуулийн химийн багш		-Завхан аймгийн Мэргэжлийн хяналтын газрын худалдаа, үйлдвэр, үйлчилгээний хяналтын улсын байцаагч
18. Дашнямын Жаргал	-Завхан аймгийн Улиастай сумын үйлдвэрлэл, үйлчилгээний «Завхан баялаг» ХК-ийн ажилчин	34. Хөхөөгийн Сүхбаатар	-Завхан аймгийн Мал үржлийн албаны малчин
19. Жамбалсүрэнгийн Жавзан	-Завхан аймгийн Прокурорын газрын нягтлан бодогч, архивч	35. Думбаагийн Төвшинжаргал	-Завхан аймгийн Тэс сумын засаг дарга
20. Бямбажавын Лхагвасүрэн	-Завхан аймгийн Улиастай сумын «Жавхлант» цогцолбор дунд сургуулийн бага ангийн багш	36. Дүндоржийн Түдэвдагва	-Завхан аймгийн Идэр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга
21. Сампилын Лхагвасүрэн	-Завхан аймгийн Улиастай сумын Чигэстэй багийн өрхийн эмнэлгийн бага эмч	37. Пэрэнлэйн Түмэнжаргал	-Завхан аймгийн Сонгино сумын Засаг даргын Тамгын газрын төрийн сангийн төлөөлөгч
22. Цээсүрэнгийн Лхагвасүрэн	-Завхан аймгийн Шуудан холбооны газрын жолооч	38. Даваанямын Уранчимэг	-Завхан аймгийн Улиастай сумын 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
23. Ванчигийн Майдархүү	-Завхан аймгийн Улиастай сумын 2 дугаар цэцэрлэгийн багш	39. Ламжавын Цэвээн	-Завхан аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн инженер-байцаагч
24. Дагвын Махмэдрий	-Завхан аймгийн Яруу сумын Засаг даргын Тамгын газрын дарга	40. Нацагийн Цэнджав	-Завхан аймгийн Завханмандал сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны улсын байцаагч
25. Дончингийн Намхайнямбуу	-Завхан аймгийн Улиастай сумын «Наймаачин» хоршооны ахлах нягтлан бодогч	41. Дашбалжирын Цэрэннадмид	-Завхан аймгийн Холбооны газрын техникч
26. Дагвадоржийн Наран	-Завхан аймгийн Улиастай сумын мандал сумын Олонтүрүү багийн Засаг дарга	42. Санжжавын Цэрэн-Очир	-Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 2 дугаар дунд сургуулийн нийгмийн ажилтан
27. Жүрмэдийн Натжав	-Завхан аймгийн Улиастай сумын зам барилга, засварын «Улбаа» ХК-ийн жолооч	43. Доржжавын Чулуун	-Завхан аймгийн Улиастай сумын 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч
28. Цагаань-Очирбат	-Завхан аймгийн Ургамал сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга	44. Чойжинжавын Чулуун	-Завхан аймгийн Сантмаргаз сумын Баяннуур багийн Засаг дарга
29. Гомбын Оюунчимэг	-Завхан аймгийн Улиастай сумын Жинст багийн Засаг дарга	45. Чимэддамбын Энх-Амгалан	-Завхан аймгийн Цагаанчулуут сумын "Шүтээн ус" хоршооны малын их эмч
30. Цэдэнддамбын Оюунчимэг	-Завхан аймгийн Улиастай сумын барилгын үйлдвэрлэлийн «Бэрсүм» ХХК-ийн төсвийн инженер	46. Цэрэнжавын Энбиш	-Завхан аймгийн Улиастай сумын "Дэвшил" дунд сургуулийн орос хэлний багш
31. Товуугийн Пүрэвжаргал	-Завхан аймгийн Улиастай сумын барилгын үйлдвэрлэлийн «Бэрсүм» ХХК-ийн төсвийн инженер		
32. Даваагийн Пүрэвсүрэн	-Завхан аймгийн Улиастай сумын үйлдвэрлэл,		

### ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Далхжавын Батбаяр	-Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч	хэлтсийн хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч
2. Түйгомбын Жамсрандорж	-Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн	

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Орон сууц барих ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

худалдах:

нь:

1. Эдийн засагт байгаа сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулах замаар орлого багатай болон дундаж орлоготой хүн амын хэсэг, төрийн албан хаагч, залуу гэр бүлийн орон сууцны хангамжийг сайжруулах, нэмэгдүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар Хадгаламж банкнаас гаргасан санаачилгыг дэмжин хэрэгжүүлэх нөхцөл бий болгох зорилгоор Засгийн газраас 6.0 (зургаан) тэрбум төгрөгийн банкны бүтцийн өөрчлөлтийн ерийн бичгийг мөнгөжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Орон сууцны хангамжийг сайжруулах, нэмэгдүүлэх зорилгоор үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан орон сууцны зээлийн бүтэц, тогтолцоог зах зээлийн харилцааны зарчимд нийцүүлэн бий болгож дор дурдсан үндсэн үүрэгтэйгээр зохион байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай:

а/зээлдүүлэгчээс үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан зээлийг худалдан авах;

б/худалдан авсан үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан зээлийг багцлаж, үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан зээлээр баталгаажсан үнэт цаас (бонд) болгон хувиргаж, хөрөнгө оруулагчдад

v/худалдан авах зээлийг сонгон

авах шалгуур, журмыг тогтоож мөрдүүлэх;

г/худалдан авах зээлийн төлбөр,

хураамжийн үйлчилгээний болон зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд зээлдэгчийн барьцаалсан үл хөдлөх хөрөнгийг хураан авах, борлуулах журмыг тогтоох.

3. Урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийг төрийн албан хаагч, залуу гэр бүлд олгох талаар холбогдох дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН  
САЙД

Б.ЖИГЖИД

САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 144

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Соёл, урлагийн сангийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Соёл, урлагийн сан байгуулах тухай" Засгийн газрын 1998 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 40 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн ... "дүрмийг нь

хавсралтын ёсоор баталсугай" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

А.ЦАНЖИД



## СОЁЛ, УРЛАГИЙН САНГИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дүрмийн зорилго нь соёл, урлагийг хөгжүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, соёл, урлагийн ажилтны мэргэшлийг дээшлүүлэх, уран бүтээлчдэд бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд оршино.

2. Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон соёл, урлагийг хөгжүүлэх, соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, тодорхой арга хэмжээг соёл, урлагийн сан /цаашид "сан" гэх/-гаас санхүүжүүлэх, сангийн хөрөнгийг хуваарилах, бүрдүүлэхэд энэхүү дүрмийг мөрдөнө.

3. Сан нь ашгийн төлөө бус төрийн өмчийн байгууллага бөгөөд тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Сан нь харилцах данстай байна.

4. Сангийн дэргэд зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл ажиллана. Зөвлөл нь соёл, урлагийн сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд заацуулах хөрөнгийн талаар санал дүгнэлт гаргана.

5. Сангийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6. Сангийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу хуваарилах, бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, ашиглалтад хяналт тавих, зохих журмын дагуу тайлан гаргах зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг сангийн захиргаа эрхэлнэ.

7. Сангийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангах үүрэг бүхий сангийн захирал /цаашид "ерөнхий менежер" гэх/-ыг соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн /цаашид "төсвийн ерөнхийлөн захирагч" гэх/ томилно.

### Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт

8. Сангийн хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

8.1. улсын төсөв;

8.2. сангийн хөрөнгөөр зохион байгуулсан урлагийн тоглолт, уран бүтээлийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн үзэсгэлэнгээс орсон орлого;

8.3. шинэ уран бүтээл туурвих, улсын болон бус нутгийн чанартай урлаг, уран сайхны томоохон арга хэмжээ зохион байгуулах, соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлахад зориулан аж ахуйн нэгж, байгууллага, гадаад орон, олон улсын байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж;

8.4. гадаад оронд зохион байгуулсан соёлын арга хэмжээнээс орох орлого;

8.5. бусад эх үүсвэр.

9. Сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэхэд зарцуулна:

9.1. соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах;

9.2. урлаг, утга зохиолын шинэ уран бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

9.3. улсын захиалгаар бүтээх уран сайхны болон баримтат кино, үндэсний уламжлалт бөгөөд сонгодог урлагийн бүтээл туурвих;

9.4. соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйл, үндэсний соёл, урлагийг гадаадад болон өөрийн оронд сурталчилсан кино, дуу авианы бичлэг хийх, ном хэвлүүлэх, соёл, урлагийн



мэргэжлийн сонин, сэтгүүл гаргахад дэмжлэг үзүүлэх;

9.5. соёл, урлагийн тоглолт хийх, түүх, соёлын дурсгалт зүйл, уран бүтээлийн үзэсгэлэнг гадаадад болон өөрийн оронд зохион байгуулах;

9.6. хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох уран бүтээл, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах;

9.7. соёл, урлагийн байгууллагад онцгой шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал худалдан авах;

9.8. соёл, урлагийн ажилтан, уран бүтээлчдийн мэргэшил дээшлүүлэх сургалт-семинар, тэдгээрийг гадаад, дотоодод зохиогдох соёл, урлагийн арга хэмжээ, тэмцээнд оролцуулах;

9.9. хөгжмийн том хэлбэрийн болон дүрслэх урлаг, кино, ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах, "Түүхийн хүрд" баримтат кино мэдээ бүтээх;

9.10. олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, тэмцээн, үзэсгэлэн, номын яармагт оролцож, онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдийг шагнаж урамшуулах;

9.11. үндэсний соёл, урлагийг хөгжүүлэх, соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг алдаршуулах.

10. Сангийн хөрөнгийн зарцуулаагүй үлдэгдлийг дараа онд шилжүүлэн зарцуулж болно. Энэ нь тухайн байгууллагын дараа оны төсвийг батлахад бууруулж тооцох үндэслэл болохгүй.

11. Сангийн хөрөнгийг энэ дүрмийн 9-д зааснаас еер зориулалтаар зарцуулахыг хориглоно.

## Гурав. Ерөнхий менежерийн эрх, үүрэг

12. Ерөнхий менежер нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаас гадна дор

дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1. сангаас санхүүжүүлж байгаа уран бүтээл, соёл, урлагийн арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн явцад хяналт тавьж, үр дүнг тооцох, эдгээртэй холбогдсон мэдээ, тайланг гаргуулж авах, шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн санхүүжилтийг зогсоох;

12.2. төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон эрх хэмжээний хүрээнд сангийн хөрөнгийг энэ дүрэмд заасны дагуу захиран зарцуулах;

12.3. сангийн ажилтнуудыг томилж чөлөөлөх, тэдгээртэй хөдөлмөрийн хуульд заасны дагуу гэрээ байгуулан ажиллах;

12.4. сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үрэгдүүлж шамшигдуулсан аж ахуйн нэгж, байгууллага, ажилтанд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

12.5. сангийн дотоод үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал, заавар, журам гаргах, санхүүгийн баримтад нэгдүгээр гарын үсэг зурах;

12.6. сангийн хөрөнгийг энэ дүрмийн 8-д заасны дагуу бүрдүүлэх ажлыг эрхлэх, сангийн хөрөнгийг арвижуулах, хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, үйл ажиллагааг сурталчлах;

12.7. сангийн төсвийн төслийг тогтоосон хугацаанд үндэслэлтэй боловсруулж соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

12.8. сангийн хөрөнгийн зарцуулалтын явц, санхүүжүүлсэн шинэ уран бүтээл, арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн үр дүнгийн талаар төсвийн ерөнхийлөн захирагчид улирал тутам танилцуулж байх;

12.9. сангийн хөрөнгийн орлого, зарлагын тайланг зохих хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх.





## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар хот

Конвенци хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Барааг түр хугацаагаар оруулах тухай Стамбулын конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

түр хугацаагаар оруулахад таслах хуудас бүхий дагалдах дэвтэртэй холбогдон үүсэх хариуцлагыг хүлээх, баталгаа гаргах чиг үүргийг гэрээний үндсэн дээр Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимаар гүйцэтгүүлж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

1. Барааг түр хугацаагаар оруулах тухай Конвенцийн Бараа, тээврийн хэрэгслийг түр оруулах бичиг баримтын тухай хавсралт А, Үзэсгэлэн, яармаг, уулзалт болон бусад төстэй үйл ажиллагааны үеэр үзүүлэх, ашиглах барааг түр оруулах тухай хавсралт В1, Мэргэжлийн багаж төхөөрөмжийг түр оруулах тухай хавсралт В2, Боловсрол, шинэчлэх ухаан, соёлын зориулалттай барааг түр оруулах тухай хавсралт В5-д заасан барааг Монгол Улсын хилээр түр хугацаагаар оруулахад таслах хуудас бүхий дагалдах дэвтэр /карней/-ийг олгох, Монгол Улсын нутаг дэвсгэрт

2. Стамбулын конвенцийн А, В1, В2, В5 хавсралтуудад заасан барааг Монгол Улсын хилээр түр хугацаагаар оруулах эрх бүхий гаалийн байгууллагын жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2003 оны 145 дугаар тогтоолын хавсралт

### СТАМБУЛЫН КОНВЕНЦИЙН ХҮРЭЭНД БАРААГ МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ ЭРХ БҮХИЙ ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

- |   |  |
|---|--|
| 1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг дахь Гаалийн салбар | 7. Баян-Өлгий аймгийн Цагааннуур дахь Гаалийн салбар             |
| 2. Дорноговь аймгийн Замын-Үүд дахь Гаалийн газар | 8. Дорнод аймгийн Эрээнцав дахь Гаалийн салбар                   |
| 3. Улаанбаатар дахь Гаалийн газар                 | 9. Ховд аймгийн Булган дахь Гаалийн салбар (зөвхөн Булган боомт) |
| 4. Дархан-Уул аймгийн Гаалийн хороо               | 10. Увс аймгийн Боршоо дахь Гаалийн салбар                       |
| 5. Орхон аймгийн Гаалийн хороо                    |  |
| 6. Хөвсгөл аймгийн Ханх дахь Гаалийн хороо        |  |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

2000 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "ОХУ-ын нутагт буй монгол иргэдийн булш, Монгол Улсын нутагт буй орос цэргийн болон иргэдийн булшны статусын тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр"-ийг

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН  
САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.НЯМДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

хоорондын Хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН  
САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМДОРЖ

2000 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Монгол Улсын Орон нутгийн захиргаа болон ОХУ-ын субъектуудын гүйцэтгэх засаглалын байгууллагын хоорондын хамтын ажиллагааны зарчмуудын тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Хэлэлцээр"-ийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН  
САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМДОРЖ

2000 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Атомын эрчим хүчийг энх тайвны зорилгоор ашиглах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 6 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар хот

Нэрэмжит болгох тухай

Түүхэн үйл явдал тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам, холбогдох байгууллага, хамт олны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

5. Дорнод аймаг дахь хилийн 0306 дугаар ангийн 0219 дүгээр салбарыг Монгол Улсын баатар Шагдарын Гонгорын;

6. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 10 жилийн 3 дугаар дунд сургуулийг Монгол Улсын гавьяат багш Байгазайн Хурметбекийн;

7. Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 10 жилийн дунд сургуулийг төр, нийгмийн зүтгэлтэн Лувсанцэрэнгийн Цэндийн;

1. Сүхбаатар аймгийн Онгон сумын 10 жилийн дунд сургуулийг Монгол Улсын баатар Чойн Дугаржавын;

2. Дорноговь аймгийн хөгжимт драмын "Саран хөхөө" театрыг соён гэгээрүүлэгч Дүлдуйтын Равжаагийн;

3. Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын 8 жилийн дунд сургуулийг нийгэм, соёлын зүтгэлтэн Магсаржавын Дугаржавын;

8. Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн сумын 10 жилийн дунд сургуулийг Монгол Улсын баатар Дамчаагийн Дэмбэрэлийн нэрэмжит тус тус болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

4. Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын хүний их эмчийн салбарыг Монгол Улсын хүний гавьяат эмч Хумарын Сураганы;

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

А.ЦАНЖИД

5.1.7. сүү, махны чиглэлийн төрөлжсөн мал болон гахай, шувууны фермерийн аж ахуй байгуулах төслийг сонгон шалгаруулж, тэргүүн ээлжинд дэмжлэг үзүүлэх;

5.1.8. бүтээмж өндөртэй мал, амьтдыг үржлийн чиглэлээр өсгөн бойжуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид гадаад орон, байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

5.2. Хөтөлбөрийн 3.2.2-г дэвшүүлсэн зорилтуудын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.2.1. сүү, махны үхрийн эрчимжсэн аж ахуйг Улаанбаатар болон бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төвийн ойролцоо нутагт үржүүлж, одоо байгаа цэвэр болон эрлийз үхрийн аж ахуйг өргөтгөх, шинээр байгуулах бодлого баримтлах;

5.2.2. мах-ноосны хонины эрчимжсэн аж ахуйг газар тариалангийн бүс нутагт үржүүлж, одоо байгаа цэвэр болон эрлийз хонины аж ахуйг өргөтгөх, шинээр байгуулах бодлого баримтлах;

5.2.3. гахай, шувууны аж ахуйг Улаанбаатар, бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төвүүд болон хүн ам олноор төвлөрсөн бусад газруудад хөгжүүлэх бодлого баримтлах;

5.2.4. бүсийн тулгуур төв, хүн ам олноор суурьшсан хот, суурингийн ойролцоо сүүний чиглэлийн ямаа үржүүлэхийг дэмжих;

5.2.5. сүүний үхрийн загвар аж ахуйн нэгжийг баруун бүсэд дөрөв, хангайн болон зүүн бүсэд тус бүр хоёр, төвийн бүсэд зургаа, Улаанбаатарын бүсэд дөрвийг бий болгоход дэмжлэг үзүүлж үржлийн сайн чанарын өсвөр бүх, гунж бойжуулан сүүний чиглэлийн үхэр үржүүлэх аж ахуйн нэгжийг хангах чиглэлтэйгээр ажиллуулах;

5.2.6. махны үхрийн загвар аж ахуйн нэгжийг хангайн болон зүүн бүсэд тус бүр нэг, төвийн бүсэд дөрвийг эхний ээлжинд бий болгоход дэмжлэг үзүүлж, үржлийн сайн чанарын өсвөр бүх, гунж бойжуулан махны үхэр

үржүүлэх аж ахуйн нэгжийг хангах чиглэлтэй ажиллуулах;

5.2.7. мах-ноосны хонины загвар аж ахуйн нэгжийг төвийн бүсэд хоёр, зүүн бүсэд нэгийг бий болгоход дэмжлэг үзүүлж үржлийн сайн чанарын өсвөр хуц, охин төлөг бойжуулан нарийн, нарийвтар ноост хонь үржүүлэх аж ахуйн нэгжид нийлүүлэх чиглэлтэй ажиллуулах;

5.2.8. гахайн загвар аж ахуйн нэгжийг хангайн бүс болон баруун, зүүн бүсэд тус бүр нэг, төвийн болон Улаанбаатарын бүсэд тус бүр хоёрыг бий болгоход дэмжлэг үзүүлж өсвөр гахай бойжуулж иргэд, аж ахуйн нэгжийг хангах чиглэлээр ажиллуулах;

5.2.9. шувууны загвар аж ахуйн нэгжийг хангайн бүс болон баруун, зүүн бүсэд тус бүр нэг, Улаанбаатарын бүсэд дөрвийг шинээр бий болгоход дэмжлэг үзүүлэх.

5.3. Хөтөлбөрийн 3.2.3-т дэвшүүлсэн зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

5.3.1. эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн болон технологийн мэдлэг чадвар дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах:

а/эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр гадаад оронд нарийн мэргэшлийн мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах;

б/хөдөө аж ахуйн чиглэлийн их, дээд сургуулиудад эрчимжсэн аж ахуйн чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх;

в/эрчимжсэн мал аж ахуй эрхлэх ач холбогдлыг иргэдэд сурталчлах;

г/эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон сонирхогчдод тусгай хөтөлбөрөөр сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулах.

5.3.2. шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх, өндөр ашиг шимт мал, амьтан, тэдгээрийн үр хөврөл үр гадаадаас авах, үржлийн материал солилцох, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах;



а/цөм сүргийн малд зохиомол хээлтүүлэг хийх, үр, хөврөл үр шилжүүлэн суулгах зэргээр өсвөр мал бойжуулан борлуулах ажлыг дэмжих;

б/эрчимжсэн аж ахуй хөгжүүлэх бүс нутагт олон улсын жишигт нийцэхүйц үржил селекцийн чиглэлийн аж ахуй, явуулын үйлчилгээг бий болгох;

в/өндөр ашиг шимт малын үр, хөврөл үрийг малын генийн санд хадгалах;

г/зах зээлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн мал, амьтдын бүтээмжийг нэмэгдүүлэх сонгон үржүүлгийн арга болон технологи, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн байрны зураг төсөл, техник, технологи боловсруулахад эрдэмтэд, мэргэжилтнүүдийн хүчийг төвлөрүүлэх;

д/эдийн засгийн бүсийн байгаль, уур амьсгалын нөхцөлд тохируулан тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа, туршилтын ажил явуулах;

е/үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцуулах худалдаа, эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл, технологийн үзэсгэлэнг улсын хэмжээнд зохион байгуулах;

ж/эрчимжсэн мал аж ахуйн ололт, амжилтыг урамшуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.

5.3.3. Малын төрөл, ашиг шимийн чиглэл, түвшинд тохирсон төгс чанарын тэжээлээр хангах нөхцөл бүрдүүлэх:

а/эрчимжсэн аж ахуйг технологийн зохистой хэмжээгээр эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шаардагдах эдлэн, бэлчээр, хадлангийн газрыг хууль тогтоомжид нийцүүлэн давуу эрхээр эзэмшүүлэх;

б/тэжээлийн зарим үйлдвэрийг сэргээх, бүрэн найрлагат тэжээл үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, дэвшилт техник, технологи нэвтрүүлэх;

в/өвс бэлтгэх хурдавчилсан

технологи нэвтрүүлж өндөр нягтралтай боох, нийлэг уутанд дарш хийх, олон найрлагат хорголжин, багсармал тэжээл, макро, микро элементээр баяжуулсан эрдсийн шахмал, уурагжуулсан, витаминжүүлсэн тэжээл үйлдвэрлэлийг дэмжих;

г/тариалангийн сэлгээнд нэг ба олон наст, үет, буурцагт тэжээлийн ургамал оруулах, тэжээлийн ургамлын үр үржүүлэх үүсгэл санаачилгыг дэмжих;

д/тэжээлийн нэг ба олон наст ургамлын үрийг дотооддоо үйлдвэрлэх, үрийн зохих нөөцтэй болох асуудлыг бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах;

е/эдэлбэр газрыг хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг сэргээх, усан сан, усалгааны шуудуу барих, шинээр худаг, уст цэг гаргахад дэмжлэг үзүүлэх.

5.3.4. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийг дараах чиглэлээр хоршин ажиллахыг дэмжинэ:

а/тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүд эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх.

б/махны төрөлжсөн аж ахуй эрхлэгчид мах боловсруулах үйлдвэрлэгчтэй; нарийн, нарийвтар ноос үйлдвэрлэгчид нэхмэл, сүлжмэл үйлдвэрлэгчтэй; сүү үйлдвэрлэгч нь сүү боловсруулах үйлдвэрлэгчтэй хоршин ажиллах;

в/эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид хоршин бэлчээр сайжруулах, тэжээл бэлтгэх, усалгаатай тэжээл бий болгох, бүтээгдэхүүнээ борлуулах зэрэг үйл ажиллагааг өргөжүүлэх;

г/эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид салбарын төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

д/мал бордох, мах боловсруулах үйлдвэрийн цогцолбор бий болгох.

## Зургаа. Хүлээгдэж буй үр дүн

6.1. Эрчимжсэн мал ахуйг эрхлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдэнэ.

6.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн бизнесийн болон технологийн мэдлэг чадвар дээшилнэ.

6.3. Малын үүлдэрлэг байдал сайжирч, бүтээмж нэмэгдэж, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн орлого, амьжиргааны түвшин дээшилнэ.

6.4. Бүсийн тулгуур төв, орон нутгийн хөгжлийн төв, суурин газрын хүн амын хүнсний хангамж дээшилнэ.

## **Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт**

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, арга зүйгээр хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мал эмнэлэг, үржлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хангаж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллана.

7.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбарын төрийн бус байгууллага, мэргэжлийн болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага оролцоно.

7.4. Хөтөлбөрт заасан эрчимжсэн аж ахуйг мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгж байгуулж ажиллуулна.

## **Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилт**

8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана:

8.1. Тухайн иргэн, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө;

8.2. Улсын төсөв;

8.3. Урт хугацааны зээл;

8.4. Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж, хөрөнгө оруулалт;

8.5. Байгууллага, иргэдийн хандив.

## **Ес. Хөтөлбөрийн шалгуурыг хэмжих үзүүлэлт**

Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуурыг дараахь үзүүлэлтээр хэмжинэ:

9.1. Эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх таатай орчин бүрдүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас хөтөлбөрийн дагуу гаргасан эрх зүйн баримт бичгүүд, түүний хэрэгжилт;

9.2. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бизнесийн болон технологийн мэдлэг олгох чиглэлээр зохион байгуулсан сургалт, үзүүлэх сургууль, тэдгээрт хамрагдсан хүний тоо;

9.3. Бүсийн тулгуур төвүүдийн ойролцоо байгуулагдсан загвар болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа аж ахуйн нэгж, шинээр бий болсон фермерүүдийн тооны өсөлт;

9.4. Улсын нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийн жин, нэгжээс авах ашиг шимийн өсөлт;

9.5. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн орлого болон амьжиргааны түвшингийн өсөлт;

9.6. Мах, сүү, өндөг зэрэг бүтээгдэхүүний өсөлт, махны экспорт болон мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүний импортын хэмжээ;

9.7. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өсөлт, бууралт, хөрөнгө оруулалтын нийгмийн үр ашиг болон иргэдийн санал, гомдлын байдал;

9.8. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд газрыг урт хугацаагаар ашиглуулсан болон эзэмшүүлсэн байдал, түүнчлэн нөхөн сэргээсэн, тарималжуулсан талбай, талхлагдсан газрын багасалт зэрэг газрын төлөв байдлын үзүүлэлт;

9.9. Эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлсэн гадаад орон, олон улсын байгууллагын төслүүд, түүний үр нөлөө.



Засгийн газрын 2003 оны 160 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

## ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭХ АЙМАГ, СУМЫН ЖАГСААЛТ

Аймгийн нэр	№	Сумын Нэр	Үржүүлэх малын төрөл			
			Сүүний үхэр	Махны үхэр	Мах-ноосны хонь	
1	Баян-Өлгий	1	Бугат	+		
		2	Өлгий	+		
2	Завхан	3	Алдархаан	+		
		4	Цагаанхайрхан	+		
3	Увс	5	Тариалан	+		
4	Ховд	6	Булган		+	
		7	Буянт	+		
		8	Зэрэг		+	
		9	Манхан		+	
		10	Мянгад	+		
5	Архангай	11	Түвшрүүлэх		+	
6	Баянхонгор	12	Өлзийт	+		
7	Булган	13	Бугат	+		
		14	Орхон	+		
		15	Сэлэнгэ		+	
		16	Хутаг		+	
8	Орхон	17	Баян-Өндөр	+		
		18	Жаргалант	+		
9	Өвөрхангай	19	Өлзийт	+		
		20	Хархорин	+		
10	Хөвсгөл	21	Тариалан		+	
11	Дархан-Уул	22	Дархан	+	+	
		23	Орхон	+		
		24	Хонгор	+	+	
		25	Шарын гол	+		
		26	Алтанбулаг	+	+	
12	Сэлэнгэ	27	Баруунбүрэн		+	
		28	Баянгол	+	+	
		29	Ерөө			+
		30	Жавхлант		+	
		31	Мандал	+	+	
		32	Орхон		+	+
		33	Орхонтуул		+	
		34	Сайхан	+	+	+
		35	Түшиг		+	
		36	Хушаат		+	
		37	Хүдэр		+	
		38	Цагааннуур	+	+	+
13	Төв	39	Аргалант	+		
		40	Батсүмбэр	+		
		41	Баяндэлгэр	+	+	
		42	Баянхангай	+		
		43	Баянцогт	+		
		44	Баянчандмань	+		
		45	Борнуур	+		
		46	Жаргалант	+	+	+
		47	Заамар		+	+
		48	Сүмбэр	+	+	
		49	Сэргэлэн	+		
50	Угтаал			+		
		51	Цээл		+	
		52	Эрдэнэ	+		



14	Дорнод	53	Баянтүмэн	+		
		54	Баян-Уул		+	
		55	Булган		+	
		56	Хэрлэн		+	
15	Сүхбаатар	57	Түмэнцогт		+	
16	Хэнтий	58	Баян-Адрага	+		
		59	Баянхутаг			+
		60	Биндэр		+	
		61	Дадал		+	
		62	Хэрлэн		+	+

Тайлбар: Нийслэлийн орчимд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг Засгийн газрын 2002 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлд мал аж ахуй эрхлэх талаар баримтлах бодлого"-д тодорхой заасан болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

### Хөтөлбөрийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2003 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчийг 2003 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 1 дүгээр хавсралтын 4 дэх заалтын "хувьчлах арга, хэлбэр нөхцөл" гэсэн 7 дэх баганад "Төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгон нээлттэй дуудлагын худалдааны аргаар" гэснийг "Нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар" гэж өөрчилсүгэй.

2. "Шарын гол" ХК-ийн нийт хувьцааг нэг багц болгон нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН  
ЗАСГИЙН САЙД

Ч.УЛААН

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2003 оны 7 дугаар сарын 4-ний өдөр

Дугаар 163

Улаанбаатар хот

### Үл хөдлөх хөрөнгө худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, 29 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Стандартчилал, хэмжил зүйн төвийн эзэмшлийн Сонгинохайрхан дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлаж байгаа байрны "Б" корпусын 2 давхар барилгыг нийтийн дуудлага худалдаагаар худалдахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

хөгжүүлэх хөтөлбөрт туссан урт, цахилгаан чадлын эталоныг шинээр бий болгох болон спирт, архины зэрцуулалтын тоолуур шалгаж баталгаажуулах эталон төхөөрөмж худалдан авахад шаардлагатай зардлыг санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД

Ч.ГАНЗОРИГ

2. Нийтийн дуудлага худалдаанаас орсон орлогыг хэмжлийн нэгжийн үндэсний эталоныг

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2